

КОВИД-19 Баярын аюулгүй байдлын зөвлөмж

Уулзалтын үеэр хэн нэгэн өөр өөр айлаас ирсэн хэдийн чинээ **олон хүнтэй** харилцаж, биеэрээ **ойрхон** хүрэлцэж, **удаан хугацаанд** харилцана тухайн хүнд шинж тэмдэг илэрсэн эсэхээс үл хамааран КОВИД-19-н халдвар авсан хүн бусдадаа халдвар тараах төдий чинээ **өндөр эрсдэлтэй**.

Хамгийн аюулгүй арга бол гэртээ гэрийнхэнтэйгээ тэмдэглэх юм. Хэрэв та баяраар уулзаж тэмдэглэхээр шийдвэл гэрээсээ гадуур таны ойр дотны хүмүүст КОВИД-19-н тархахыг хэрхэн бууруулах талаар бодож үзээрэй. Зарим санаанаас дурдвал:



Уулзалтаа төлөвлөх:

- Аль болох цомхон байлгах. Зочдынхоо тоог хязгаарлах, зайнаас оролцохыг дэмжих.
- Өвчтэй, шинжилгээний хариу сөрөг гарч, тусгаарласан эсвэл шинжилгээний хариугаа хүлээж байгаа хүмүүсийг оролцуулахгүй байх.
- Өөр хоорондоо зай авах боломжгүй үед, ялангуяа дотор байхад зочдыг амны хаалтаа зүүхийг хүсэх.
- Хоорондын зайг тооцож сандлын байршлыг зохион байгуулах. Хэрэв боломжтой бол гэр бүл тус бүрээр нь тусдаа ширээнд суулгах.
- Уулзалтыг аль болох богино байхаар төлөвлөх.
- Хэрэв уулзалтад ирсэн хэн нэгний шинжилгээний хариу сөрөг гарвал холбоо барихад ашиглахын тулд ирсэн зочидтой холбоо барих мэдээлэл бүхий жагсаалт гаргах.



Уулзалтын үеэр:

- Зочдоос хоорондын зайгаа барьж, амны хаалт зүүхийг хүсэх.
- Хэрэв боломжтой бол гадаа цуглаж уулзах.
- Ялангуяа хооллож байх үед, мөн өрөө тасалгаанд байхдаа агааржуулалтыг сайжруулах, (цонх нээх, агаар сэлгэгчийг асаах г.м).
- Гараа тогтмол угааж, олон гадаргууд хүрэхээс зайлсхийх.
- Зочдодоо хүрэлцэхүйц хэмжээний гар ариутгагч бэлдэх.



Хоол бэлтгэх/үйлчлэх явцад:

- Хоол бэлтгэхэд оролцсон хүн бүр амны хаалт зүүх.
- Хоол бэлтгэх газар байх хүний тоог хязгаарлах.
- Гэр гэрээсээ хоол авчрах буюу зочдыг гэрээсээ хоол бэлтгэн авч ирэхгүй байхыг хүсэх.
- Хүн бүр өөрөө өөртөө үйлчлэхийн оронд бүх хоолыг зөөж үйлчлэх нэг хүнтэй байх.
- Нэг удаагийн хэрэгсэл ашиглахыг хичээх.



Зочилж уулзсаны дараа:

- Хэн нэгэн өвдсөн бол өөрийгөө тусгаарлаж, шинжилгээ өгөх.
- Хэрэв хэн нэгэн зочны шинжилгээний хариу сөрөг гарвал бүх зочинтой холбоо барьж, өөрсдийгөө тусгаарлан шинж тэмдгийг ажиглаж, хэрэв шинж тэмдэг илэрвэл шинжилгээ өгөх ёстой талаар хэлэх хэрэгтэй.